



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар Б/31

Чингис хот

Г.Ариунхүүг ажлаас чөлөөлж,
Э.Ариунтунгалагийг ажилд нь үргэлжлүүлэн
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.1.4, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд асрах чөлөөтэй байсан Нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нь ажилдаа орох хүсэлт гаргасан тул албан үүргийг гүйцэтгэж байсан Г.Ариунхүүг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Хүүхэд асрах чөлөөтэй байсан Нягтлан бодогч Э.Ариунтунгалагийн хүсэлтийг үндэслэн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн уг ажилд нь үргэлжлүүлэн ажиллуулсугай.

3. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

С.Нямдаваа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Цэцэгсүрэн

Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн

Т.Бямбадулам

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа

Нярав

4. Г.Ариунхүүгийн ажил хүлээлцэх хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 01-03-ны өдрүүдээр тогтоон, хүлээлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /С.Нямдаваа/-д, холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР